



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Засгийн газрын
ТОГТООЛ

1990 оны 12 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 186

Улаанбаатар
хот

Гадаад харилцааны яамны дүрмийг
батлах тухай

БНМАУ-ын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Гадаад харилцааны яамны дүрмийг хавсралтын
ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Гадаад яамны яам-
ны дүрэм батлах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1983 оны 12 дугаар
сарын 30-ны өдрийн 341 дүгээр тогтоолыг хүчингүй болгонд тооц-
сугай.

БНМАУ-ын Засгийн газрын
Ерөнхий сайд

Д.БЯМБАСҮРЭН

БНМАУ-ын Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Д.МОЛГОМЖАМЦ

Засгийн газрын 1990 оны 186
дугаар тогтоолын хавсралт

БНМАУ-ЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. БНМАУ-ын Гадаад харилцааны яам нь төрийн гадаад бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг эрхлэх төрийн захиргааны төв байгууллага мөн.

2. Гадаад харилцааны яамны үндсэн зорилт нь БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, амьжиргаа байдлыг хангах үүднээс тус улсын эрх ашгийг олон улсын тавцан дээр хамгаалж, нэр хүнд, байр суурийг нь бататгах, улс орны эдийн засаг, нийгмийн тулгамдсан гол гол зорилтыг хэрэгжүүлэх гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх, улс үндэстнийхээ эрх ашгийг удирдлага болгон гадаад орнуудтай найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд БНМАУ-ын хүлээх олон улсын үүргийг хангуулахад оршино.

3. Гадаад харилцааны яам үйл ажиллагаандаа БНМАУ-ын Үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль, хууль тогтоомжийн бусад акт, энэ дүрэм, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг удирдлага болгоно.

4. Гадаад харилцааны яам үйл ажиллагаагаа БНМАУ-ын Ерөнхийлөгч, Улсын Бага Хурал, Засгийн газрын удирдлагын дор бусад холбогдох яам, улсын хороо, тусгай газартай уялдуулан явуулна.

5. Гадаад харилцааны яамыг БНМАУ-ын Бага Хурлаас томилсон Гадаад харилцааны сайд толгойлж, яамны зорилт, үүргийг хэрэгжүүлэх ажлыг БНМАУ-ын Засгийн газрын өмнө бүрэн хариуцна.

6. Гадаад харилцааны сайд эрх хэмжээнийхээ асуудлаар БНМАУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж биелэлтийг нь зохион байгуулж хангуулна.

2.

7.Гадаад харилцааны яамны зорилт, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байхын тулд сайдын зөвлөл ажиллана.Зөвлөлийг сайд толгойлно.Зөвлөлийн гишүүд, дүрмийг сайдын тушаалаар батална.

8.БНМАУ-ын Засгийн газар Гадаад харилцааны яамны удирдлагын орон тоо, цалингийн санг баталж, тэргүүн дэд сайд, дэд сайд нарыг томилно.

9.БНМАУ-ын Засгийн газар БНМАУ-аас хилийн чанадад суух дипломат болон консулын төлөөлөгчийн газрыг байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэж, тэдгээрийн үлгэрчилсэн дүрэм, орон тоо, ажилтны цалинг тогтооход баримтлах дундаж нэгж, түүнийг үндэслэн албан тушаалын цалинг тогтоох хувийг батална.

10.Гадаад харилцааны яам зохих журмаар хийлгэсэн тамга, тэмдэг, албан бичиг, нотны хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ХОЁР.Гадаад харилцааны яамны үүрэг,эрх

II.Гадаад харилцааны яам дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлд тодорхойлсон гадаад бодлогын чиг шугамыг хэрэгжүүлэх;

б/тодорхой улс гүрэн, олон улсын байгууллагатай харилцах, түүнчлэн тодорхой асуудлаар болон бүс нутагт явуулах бодлого, арга хэмжээний талаар санал боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

в/тус улсын эрх амгийн үүднээс гадаад улс төр,эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын зэрэг харилцааны гол чиглэлүүдийн нэгдлийг хангах, уялдуулан зохицуулах үйл ажиллагаа явуулах;

г/олон улсын байдал, бусад улсын гадаад бодлого, үйл ажиллагааны онцлог асуудлаар дүн шинжилгээ хийж, БНМАУ-ын

3.

Засгийн газрын баримтлах байр суурь, чиг шугамын талаар санал боловсруулж холбогдох байгууллагад оруулах;

д/Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн болон олон улсын бусад байгууллагад БНМАУ-ыг төлөөлж, үйл ажиллагаанд нь оролцох;

е/БНМАУ бусад улстай дипломат харилцаа тогтоох, олон улсын Засгийн газар хоорондын байгууллагуудад гишүүнээр алсах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх;

ж/БНМАУ-ын эдийн засгийн гадаад бодлогыг боловсруулах, түүнийг хоёр болон олон талын хүрээнд хэрэгжүүлэхэд оролцох;

з/гадаад орон, олон улсын байгууллагуудтай эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах засгийн газар хоорондын комисс, оролцогч бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, комиссуудын ажлын апаратын үүрэг гүйцэтгэх;

и/гадаад улсын засгийн газар, олон улсын байгууллагаас авах зээл тусламжийн асуудлыг дотоодын холбогдох байгууллагатай хамтран боловсруулж шийдвэрлүүлэх, тусламжийн төслүүдийн биелэлтэд хяналт тавих;

к/манай орноос бусад улсад тусламж үзүүлэх асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх;

л/БНМАУ-ын соёлын гадаад харилцааны бодлого, арга хэмжээг төлөвлөн зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

м/тус улсын гадаад бодлого, олон улсын харилцааны цаг үеийн асуудлаар БНМАУ-ын Ерөнхийлөгч, Улсын Бага Хурал, Засгийн газрыг мэдээллээр хангах;

н/БНМАУ-ын гадаад бодлого болон үйл ажиллагааг дотоод, гадаадад мэдээлэх, танцуулах ажлыг зохион байгуулна.БНМАУ-д

4.

суурин ажиллах гадаадын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газар, сурвалжлагч нарын холбогдолтой асуудлыг зохицуулах;

о/БНМАУ-ын улсын хилийн шугам, хилийн дэглэмийг тогтоох, хил нэвтрэх журмыг тохиролцох, хилийн боомт нээх, хаах асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах болон улсын хилийн шугамыг холбогдох улстай хамтран шалгах ажлыг хариуцах;

п/БНМАУ-ын улсын хил, хилийн дэглэм, хил орчмын хамтын ажиллагааны талаархи гэрээ, хэлэлцээрийг биелүүлэх ажилд оролцох;

р/БНМАУ-ын консулын албанд холбогдох хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээрийн дагуу консулын албаны ажлыг эрхлэн явуулах;

с/БНМАУ-ын олон улсын гэрээг байгуулах, хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавихад оролцоно.

Гэрээ, хэлэлцээрт өөрчлөлт оруулах, хугацааг сунгах, цуцлахтай холбогдсон санал боловсруулж шийдүүлнэ.

БНМАУ-ын олон улсын гэрээний заалттай үндэсний хууль тогтоомж хэрхэн нийцэж байгаад хяналт тавьж, нийцүүлэх саналыг холбогдох яам, улсын хороо, тусгай газартай хамтран боловсруулах;

Байгууллага хоорондынхоос бусад БНМАУ-ын олон улсын гэрээний зинхэнэ буруу баталгаатай ажлыг хадгална;

т/БНМАУ-ын төрийн дипломат ёслолын ажлыг эрхлэн явуулах;

у/БНМАУ-ын гадаад харилцааны улсын архивын ажлыг эрхлэх;

ү/БНМАУ-д суугаа гадаад улсын болон олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчийн газрыг үйлчлэхтэй холбогдсон ажлыг эрхлэх;

х/МОНГОЛЫН ЭНХ ТАЙВАН, НАЙРАМДИЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ;

ц/ДИПЛОМАТ АЛБАНЫ БОЛОВСОН ХҮЧНИЙГ ШИЛЖ СОНГОХ, БАЛТ-
ГЭХ, ДАВТАН СУРГАХ, ХУВААРИЛАХ АСУУДИНГ ЭРХЛЭХ.

12. Гадаад харилцааны яам дор дурдсан эрх эдэлнэ:

а/БНМАУ-ын гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хү-
рээнд бусад улс, олон улсын байгууллагын төлөөлөгчтэй яриа
хэлэлцээ хийх, захидал бичиг солилцох, зохих журмын дагуу
гэрээ, хэлэлцээр байгуулах;

б/олон улсын харилцааны асуудлаар БНМАУ-ын Засгийн
газрын байр суурийг зохих хэлбэрээр илэрхийлэх;

в/БНМАУ-ын яам, хороо, тусгай газар, аймаг, хотын
Хурлын гүйцэтгэх захиргаанд гадаад харилцааны асуудлаар са-
нал, зөвлөмж өгөх;

г/гадаад харилцааны ажилд шаардагдах мэдээ, судалгаа,
тооцоог яам, улсын хороо, тусгай газар, аймаг, хотын Ардын
Хурлын гүйцэтгэх захиргаа, бусад албан газар, байгууллагаас
гаргуулан авах;

д/эрх бүхий байгууллагын шийдвэрийн үндсэн дээр олон
улсын гэрээ хэлэлцээр байгуулах, хурал, уулзалтад оролцох
БНМАУ-ын төлөөлөгчдөд бүрэн эрхийн үнэмлэхийг зохих журмын
дагуу шийтгэн олгох;

е/БНМАУ-ын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, эл-
чин зөвлөх, зөвлөх, ерөнхий консул нарыг томилгох, эгүүлэн
татах санал боловсруулж шийдвэрлүүлэх;

ж/БНМАУ-ын хэргийг хамаарагч, консулыг тохоон томил-
сон захидал, патент олгох, гадаад улсын хэргийг хамаарагч,
консулыг тохоон томилсон захидал, патентыг хүлээн авч аккредитаци-
онг консулуудад олгох;

з/БНМАУ-ын дипломат төлөөлөгчийн газруудыг шинээр байгуулах, татан буулгах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах, Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарын хавсран суух орнуудыг товож тэднийг томилуулах;

и/БНМАУ-ын дипломат төлөөлөгчийн газрын ажилтнуудыг томлох, эгүүлэн дуудах, цалингийн санд багтаан орон тоог нь зохицуулах;

к/төв аппаратын зохион байгуулалтын бүтцийг өөрчлөх, газар, хэлтсийн дарга нарыг томлох, ажилтан нарыг хуваарилах;

л/албан хаагч, ажилчдыг шагнах урамшуулах, дипломат цол олгох асуудлыг эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах, дипломатын дээд цол олгуулах тухай саналыг холбогдох байгууллагад оруулах;

м/хөдөлмөрийн сахилга, ажлын хариуцлага алдсан албан хаагч, ажилчдад зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;

н/батлагдсан төсвийг зарцуулах, түүний хэмнэгдэл болон төсвийн галуурх орлогоос өөрийн мэдлийн сан байгуулж зарцуулах;

о/БНМАУ-ын дипломат төлөөлөгчийн болон консулын газруудтай харилцахдаа нууц түүхүүр ашиглах;

п/Талаад харилцааны яамны төв аппаратын бүтцийн нэгж, харьяа байгууллагын дүрмийг баталж мөрдүүлэх.